



МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДЫН ХОЛБООН
ҮНДСЭН ДҮРЭМ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРОНХИЙ ГАЗАР
УЛСЫН БҮРТГӨГЧ 572

Хуулийн эзгээдлийн ижил бүртгэлийн
дугаар 9071018034

2022 оны 06 сарын 02 сар

Бүртгэсэн: Улсын (ахлах) бүртгэгчийн

гарын усэг

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэгдүгээр зүйл. Ерөнхий зүйл

- 1.1. Монголын Залуучуудын Холбоо (цаашид МЗХ гэх) нь Монголын залуучуудын оролцооны нэгдмэл үндэсний төв байгууллага бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажиллах ашгийн бус нийгэмдээ үйлчлэх төрийн бус байгууллага мөн.
- 1.2. МЗХ-ны оноосон нэр:
 - 1.2.1 Монгол хэл дээр: "Монголын Залуучуудын Холбоо"
 - 1.2.2 Англи хэл дээр: "Mongolian Youth Federation"
- 1.3. МЗХ болон бүх салбар холбоо, хороо, зөвлөл, дэргэдэх байгууллага, сонирхлын клубууд (цаашид " Салбар нэгж " гэх) нь МЗХ-ны Удирдах хорооноос баталсан журмын дагуу бэлэг тэмдэг (лого), туг, далбаа, албан бичгийн загвар, энгэрийн тэмдэг, үнэмлэх, хэвлэмэл хуудсыг тус тус хэрэглэнэ.
- 1.4. МЗХ болон бүтцийн бүх шатны байгууллагууд нь өөрийн тамга, тэмдэг, банкинд харилцах данс, гэрчилгээтэй байж болно.
- 1.5. МЗХ-ны төв байр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 42-т байрлана. www.myf.mn вэб сайт, info@myf.mn цахим шуудантай байна.
- 1.6. МЗХ нь үйл ажиллагаандaa Монгол Улсын Үндсэн хууль, төрийн бус байгууллагын харилцааг зохицуулсан хууль болон энэхүү дүрэм, түүнд нийцүүлэн гаргасан бусад журмыг мөрдөж ажиллана.
- 1.7. МЗХ нь гишүүний тангарагтай байх бөгөөд идэвхтэн гишүүний үнэмлэхээ гардан авч тангараг өргөнө.
- 1.8. МЗХ-ны үйл ажиллагааны хамрах хүрээ нь Монгол Улсын нутаг дэвсгэр, салбар холбоо, зөвлөлтэй гадаад улс оронд хэрэгжиинэ.

Хоёрдугаар зүйл. Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл, зарчим

МЗХ нь дараах Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйл, зарчмыг үйл ажиллагаандaa мөрдлөг болгоно.

2.1. Алсын хараа

Монгол Улсын хөгжлийг хөтлөх, эрх мэдэлтэй, нэгдсэн залуучууд

2.2. Эрхэм зорилго

Монголын залуучуудын эрх ашгийг хамгаалах, дэмжих зорилгоор тэдгээрийн оюун ухаан, сэтгэлгээ, бие бялдрыг хөгжүүлэх, бие даасан, зорилготой, шударга, аз жаргалтай амьдрах боломжоор хангах явдал юм.

2.3. Үнэт зүйл

2.3.1. Эв нэгдэлтэй байх: МЗХ Монгол Улсыг шударга, хөгжингүй улс болгох гол хүч болсон залуучуудыг эв нэгдэлтэй байж, бие биенээ дэмжин хамтран ажиллахад уриална.

2.3.2. Ил тод байдал: МЗХ нь өөрийн бүхий л үйл ажиллагаанд ил тод байх зарчмыг баримталж, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудад мөн адил ил тод байхыг уриална.

2.3.3. Эрх мэдэлтэй байх: МЗХ-ноос Монголын залуучуудын эрх мэдэлтэй байхыг дэмжих бөгөөд улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд нөлөөлөх, оролцох эрхийг нэн тэргүүнд тавина.

2.3.4. Ардчилсан зарчим: МЗХ нь эрх чөлөөтэй, шударга ардчилсан зарчмаар үйл ажиллагаагаа явуулна

2.3.5. Бие даасан байх: МЗХ-нд залуучуудын төлөө залуучууд өөрсдөө ажиллах бөгөөд энэхүү бие даасан байдал нь ямар нэг дарамтгүй, эрх ашгийн зөрчилгүйгээр залуучуудыг уриалах, дэмжих гол хөшүүрэг болно.

2.3.6. Хариуцлагатай байх: МЗХ-ны бүх ажилтан, гишүүд нь өөрсдийн бүхий л үйл ажиллагаандаа хариуцлагатай хандаж, адил тэгш хариуцлагатай байхыг төрийн бус байгууллагуудад уриална.

2.3.7. Идэвхтэй иргэн байхыг дэмжих: МЗХ-ноос Монгол Улсад илүү эрх тэгш нийгэм байгуулахад залуучуудыг идэвхтэй, эерэг хандлагатай оролцохыг дэмжинэ.

2.3.8. Тогтвортой байдал: МЗХ үндэсний соёл, өв уламжлал, байгаль орчноо хамгаалах, тогтвортой эко хөгжлийг хангахыг нэн тэргүүнд тавьж ажиллана.

2.4. Зарчим

МЗХ нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

2.4.1. Хувь хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, эв нэгдэл, үндэсний тусгаар тогтнол, тогтвортой байдлыг эрхэмлэх;

2.4.2. Ил тод, хараат бус, нээлттэй, шударга ардчилсан, улс төр, шашны нөлөөнөөс ангид, идэвхтэй, хариуцлагатай, мэдлэг, судалгаанд сууринсан, бие даасан, зерэг хандлагатай байх;

2.4.3. Ирээдүйг угтаж мэдэж, тосож бэлтгэж, тэсэж давах чадварыг бурдуулэх;

2.4.4. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах.


Гуравдугаар зүйл. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

МЗХ нь өөрийн үнэт зүйл зарчимд үндэслэн энгийн, идэвхтэн, сонгуулт гишүүд, дэмжигчид, нийгэмдээ чиглэсэн дараах үйл ажиллагааг үндсэн чиглэлээ болгоно. Үүнд:

3.1. Зорилт

3.1.1. Монголын залуучуудыг тэргүүлэгч, үндэсний хэмжээний төв байгууллагын байр суурийг бэхжүүлэх;

3.1.2. Монголын залуучуудын хөгжлийг дэмжих, зорилготой, шударга, үр бүтээлтэй амьдралыг дэмжин ажиллах;



3.1.3. Улс төр, эдийн засаг, бизнес, нийгэм, олон улс, төрийн бүхий л түвшинд залуучуудын төлөөлөл, нөлөөллийг нэмэгдүүлэх;

3.2. Үйл ажиллагааны чиглэл

3.2.1. Залуучуудын асуудлаарх бодлогыг боловсруулах, шийдвэр гаргах түвшинд хүргэх, сурталчлах;

3.2.2. Залуучуудад тулгамдаж буй асуудлаар залуучуудад чиглэсэн бодлогын судалгаа хийх, түүнд үндэслэн залуучуудын дэмжих төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг зохион байгуулах;

3.2.3. Залуучуудын нийтлэг хүсэл эрмэлзэл, эрх ашгийг хамгаалах, ухамсартай, эрүүл, бүтээлч, идэвхтэй, оролцоотой, ёс зүйтэй залуу хүнийг зөв төлөвшүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;

3.2.4. Улс төр, эдийн засаг, бизнес, нийгэм, олон улс, төрийн бүхий л түвшинд шинэ залуу удирдагчдыг төрүүлэн гаргах бэлтгэх, төлөвшүүлэх;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дөрөвдүгээр зүйл. МЗХ-ны бүтэц

4.1. МЗХ-ны удирдах дээд байгууллага нь Их хурал (ИХ) мөн.

4.2. ИХ-ын хооронд ажиллах төлөөллийн төв байгууллага нь Үндэсний Залуучуудын Зөвлөл /ҮЗЗ/ байна.

4.3. МЗХ-ны хяналтын байгууллага нь Хяналтын Зөвлөл (ХЗ) байна.

4.4. ҮЗЗ-ийн чөлөөт цагт МЗХ-г шуурхай удирдлагаар хангах бодлого удирдлагын төв байгууллага нь Удирдах Зөвлөл (ҮЗ) байна.

4.5. " МЗХ-ны удирдлага " гэснийг Ерөнхийлөгч , Удирдах зөвлөлийн гишүүн, Ерөнхий нарийн бичгийн дарга гэж ойлгоно.

4.6. МЗХ-г өдөр тутмын байнгын удирдлага, зохион байгуулалт, бэлэн байдлаар хангах гүйцэтгэх байгууллага нь Гүйцэтгэх Хороо (ГХ) байна.

4.7. МЗХ-ны салбар холбоо, дэргэдэх байгууллагууд дараах байдлаар ангилагдана. Үүнд:

4.7.1. Залуучуудын асуудал хариуцсан ҮЗЗ-ийн байнгын хороод;

4.7.2. Нийслэл, Аймаг, дүүрэг, сум, хорооны салбар холбоод;

4.7.3. Нийслэл, Аймаг дүүргийн залуучуудын чуулган, бага чуулган;

4.7.4. Баг, хэсэг, байгууллагын залуучуудын зөвлөл;

4.7.5. Ахмадын, оюутны, хүүхдийн асуудал эрхэлсэн холбоо;

4.7.6. Чиглэлийн залуучуудын холбоо;

4.7.7. Хүсэл сонирхлоороо нэгдсэн залуучуудын клуб;

4.7.8. УИХ, аймаг, нийслэл, сум дүүрэг, хороо, багийн иргэдийн хурлын дэргэдэх залуучуудыг дэмжих лобби бүлэг;

4.7.9. Төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудын залуучуудын зөвлөл;

4.7.10. Гадаад улс оронд байрлах Монголчуудын нэгдсэн залуучуудын холбоо, хороо, зөвлөл;



- 4.7.11. Холбооны үйл ажиллагааг дэмжих, санхүүжүүлэх компани, сургалт, судалгаа, хөгжлийн төв, сан;
- 4.7.12. Залуучуудын хэвлэлийн нэгдсэн редакцтэй байна.

Тав дугаар зүйл. Их хурлын бүрэн эрх

5.1 МЗХ-ны ИХ ХУРАЛ нь МЗХ-ны удирдах дээд байгууллага мөн.

5.2. ИХ нь 2 жилд нэг удаа хуралдана. Онцгой тохиолдолд ээлжит бус ИХ-ыг зарлан хуралдуулж болно. Ерөнхийлөгч, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн аль нэгний санал болгосноор ҮЗЗ-ийн хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхын саналаар ээлжит бус ИХ-ыг зарлан хуралдуулна.

5.3 ИХ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд;

- 5.3.1. ИХ-ын дарга Ерөнхийлөгч байна;
- 5.3.2. Ерөнхийлөгчийн тайлан илтгэлийг хэлэлцэх;
- 5.3.3. ХЗ-ийн тайланг хэлэлцэх;
- 5.3.4. Үндсэн дүрэм, үзэл баримтлалыг хэлэлцэж батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
- 5.3.5. Ерөнхийлөгч болон Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох, чөлөөлөх;
- 5.3.6. МЗХ-ны хурлын үйл ажиллагаа зохион байгуулалт, дэгийн тухай журмыг хэлэлцэн баталж, нэмэлт өөрчлөлт оруулах;
- 5.3.7. МЗХ-ны бүтцийн бүх шатны байгууллагын удирдах бүрэлдэхүүнийг сонгох сонгуулийн журмыг хэлэлцэн баталж, нэмэлт өөрчлөлт оруулах;
- 5.3.8. МЗХ-ны татварын журмыг хэлэлцэн баталж, нэмэлт өөрчлөлт оруулах;
- 5.3.9. МЗХ-ны ХЗ-ийн гишүүдийг сонгох, чөлөөлөх;
- 5.3.10. ИХ-ын дүрэмд өөрчлөлт оруулахаас бусад зарим бүрэн эрхээ ҮЗЗ, онцгой үед ҮЗ, Ерөнхийлөгчид эрхийг тус, тус шилжүүлж болно;
- 5.3.11. ИХ-ын бүрэн эрхэд бусад асуудлуудыг хамааруулж болно;

Зургадугаар зүйл. Үндэсний залуучуудын зөвлөлийн бүрэн эрх

6.1. ҮЗЗ-ийн гишүүний суудлын тоо 339 байна. Жил бүр ҮЗ-ийн тогтоосон квотоор, тогтсон хугацаанд ҮЗЗ-ийн гишүүний эргэлтэд хамрагдах /ротаци/ сонгууль явагдана.

6.2. ҮЗЗ-ийн гишүүдийг чөлөөт, чөлөөт бус гишүүд гэж ангилна. ҮЗЗ-ийн чөлөөт бус суудлын тоо нийт гишүүдийн 2/3, чөлөөт суудлын тоо нийт гишүүдийн 1/3 байна.

6.3 Эргэлтэд орсон ҮЗЗ-ийн суудал дээрх гишүүн хариуцлага тооцогдоноос бусад тохиолдолд дахин сонгогдох эрхтэй.

6.4. ҮЗЗ-ийн гишүүний суудлын тоог ҮЗ нь МЗХ-ны бүтцийн бүх шатны байгууллагын тооноос хамаарч хуваарлина.

6.5. ҮЗЗ нь жилд 2-оос доошгүй удаа хуралдана.

6.6. ҮЗЗ-ийн хурлын товыг уг хурал болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө Ерөнхийлөгч, Удирдах зөвлөл зарлана. ҮЗЗ-ийн ээлжит бус хурлын товд дээрх хугацаа хамаарахгүй.

6.7. ҮЗЗ-ийн гишүүн чөлөөлөгдэхийг хүсвэл хүсэлтээ ХЗ-д бичгээр гаргана.

6.8. Хүсэлтээ гаргаснаар ҮЗЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдсөнд тооцно.

6.9. Хүсэлтийг хүлээн авсан ХЗ нь Ерөнхийлөгчид 3 хоногийн дотор албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй.



6.10. Үндэсний залуучуудын зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 6.10.1. МЗХ-ны ИХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 6.10.2. МЗХ-ны бодлого чиглэл, залуучуудын хөгжлийн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох асуудлууд, залуучуудад тулгамдаад байгаа асуудлуудыг хэлэлцэх, зөвлөмж шийдвэр гаргах, УЗ-д чиглэл өгөх;
- 6.10.3. ҮЗ33-ийн хурлын хооронд зохион байгуулагдсан гишүүний нөхөн сонгуулийн дүнг батламжилах;
- 6.10.4. УЗ-ийн гишүүнийг нөхөн сонгох;
- 6.10.5. ХЗ-ийн гишүүнийг нөхөн сонгох;
- 6.10.6. ҮЗ33-ийн нийт гишүүдийн 2/3-ын саналаар МЗХ-ны Үндсэн дүрмэнд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 6.10.7. МЗХ-ны цаг үеийн бодлого, хөтөлбөрийн батлах;
- 6.10.8. Ээлжит болон ээлжит бус ИХ хуралдуулах тов, хэлэлцэх асуудлыг тогтоох;
- 6.10.9. МЗХ-ны ИХ, ҮЗ33-ийн хурлын тэргүүлэгчдийг сонгох, чөлөөлөх;
- 6.10.10. ҮЗ33 нь зарим бүрэн эрхээ УЗ, Ерөнхийлөгчид шилжүүлж болно.
- 6.10.11. ҮЗ33 нь дараах журмуудыг баталж мөрдүүлнэ. Үүнд:
 - 6.10.11.1. МЗХ-ны хурлын үйл ажиллагаа зохион байгуулалт, дэгийн тухай журам батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
 - 6.10.11.2. МЗХ-ны бүтцийн бүх шатны байгууллагын удирдах бүрэлдэхүүнийг сонгох сонгуулийн журам батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
 - 6.10.11.3 МЗХ-ны бүтцийн бүх шатны удирдах бүрэлдэхүүн, гишүүний ёс зүйн дүрэм батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
 - 6.10.11.4. МЗХ-ны татварын журам батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
 - 6.10.11.5. ХЗ-ийн үйл ажиллагааны журам батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;

6.11. ҮЗ33-ийг хуралдуулах бэлтгэл ажлыг ГХ хангах бөгөөд хэлэлцэх асуудлыг УЗ шийдвэрлэнэ.

6.12. ҮЗ33-ийг түүний гишүүдийн 1/3-ээс доошгүй шаардлагаар Ерөнхийлөгч тарааж дараагийн ҮЗ33-ийг шинээр бүрдүүлнэ.

6.13. ҮЗ33-ийн хурлын хооронд батлагдсан бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг залуучуудын асуудал хариуцсан байнгын хороо (БХ) хангуулах бөгөөд дүн шинжилгээг ГХ хариуцаж ҮЗ33-д танилцуулна.

Долоодугаар зүйл. Ерөнхийлөгчийн бүрэн эрх, үүрэг

- 7.1. МЗХ-ны Ерөнхийлөгч /цаашид “Ерөнхийлөгч”/ гэх нь Удирдах зөвлөлийн дарга бөгөөд Ерөнхийлөгч нь орон тооны болон орон тооны бус байж болно.
- 7.2. МЗХ-ны Ерөнхийлөгч нь нэг удаа улиран сонгогдож болно.
- 7.3. МЗХ-ны Ерөнхийлөгч нь ИХ-д ажлаа тайлагнана.
- 7.4. МЗХ-ны Ерөнхийлөгч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 7.4.1. ИХ-ын хооронд МЗХ-ны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- 7.4.2. ИХ, ҮЗ33, УЗ-ийн хурлыг даргалах;



- 7.4.3. ЕНБД болон УЗ-ийн гишүүнийг томилуулах, чөлөөлөх саналыг УЗ-д оруулах;
 - 7.4.4. МЗХ-ны УЗ-ийн хурлыг товлон зарлах, хуралдуулах;
 - 7.4.5. Дотоод, гадаад харилцаанд МЗХ-г бүрэн төлөөлөх;
 - 7.4.6. Бүтцийн бүх шатны байгууллагуудын аливаа шийдвэрт хориг тавих;
 - 7.4.7. Бүтцийн бүх шатны байгууллагуудын удирдах бүрэлдэхүүнийг үүргээ хангалтгүй гүйцэтгэж байна гэж үзсэн тохиолдолд үндэслэл гарган тухайн салбар нэгжийн хурлыг зарлан хуралдуулах саналыг Удирдах зөвлөл болон тухайн Салбар нэгжид оруулах;
- 7.5. МЗХ-ны Ерөнхийлөгчийг дараах үндэслэлээр чөлөөлнө. Үүнд:
- 7.5.1. Чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;
 - 7.5.2. Ерөнхийлөгчийн хавсарч үл болох албан тушаалд сонгогдсон, томилогдсон;
 - 7.5.3. Эрүүл мэндийн шалтгаанаар;
 - 7.5.4. Нас барсан шалтгаанаар
 - 7.5.5. Гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон;

Наймдугаар зүйл. Удирдах зөвлөлийн бүрэн эрх, үүрэг

- 8.1. МЗХ-ны УЗ нь Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн 32 нийт 33 гишүүнээс бүрдэнэ.
- 8.1.1 МЗХ-ны УЗ-ийн гишүүнийг УЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар түдгэлзүүлж, үүрэг гүйцэтгэгч томилж болно.
- 8.2. Удирдах зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Ерөнхийлөгчийн эзгүйд ерөнхийлөгчийн бичгээр санал болгосон УЗ-ийн гишүүн эсвэл насаар ахмад гишүүн хурлыг даргална.
- 8.3. УЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 8.3.1. УЗ33-өөс батлан гаргасан урт, дунд хугацааны бодлого, чиглэл хөтөлбөр, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
 - 8.3.2. УЗ33 болон ИХ-ын хуралдааны товыг гишүүдийн олонхын саналаар тогтоох, бэлтгэлийг хангах, хэлэлцэх асуудлыг батлах;
 - 8.3.3. УЗ нь бүтцийн болон дэргэдэх байгууллагуудыг нэгдмэл удирдлагаар хангах;
 - 8.3.4. МЗХ-ны бодлого, үйл ажиллагааны ойрын чиглэлийг тодорхойлох;
 - 8.3.5. УЗ нь МЗХ-ны жилийн ерөнхий төлөвлөгөөг батлах;
 - 8.3.6. МЗХ-ны ГХ-ны тайланг хэлэлцэх, үйл ажиллагаанд дүгнэлт өгөх;
 - 8.3.7. УЗ нь ГХ-ны орон тоо, бүтэц, төсвийг батлах;
 - 8.3.8. УЗ-ийн хурал нь Хяналтын зөвлөлийн төлөөллийг оролцуулснаар хүчин төгөлдөр байна.
 - 8.3.9 УЗ-ийн гишүүдийн 2/3 саналаар УЗ-ийн хурлыг зарлан хуралдуулах;

Есдүгээр зүйл. Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрх, үүрэг

- 9.1 Удирдах зөвлөлийн гишүүн нь УЗ33-ийн аль нэг байнгын хороонд харьяалагдана.
- 9.2 Удирдах зөвлөлийн хуралд асуудал дэвшүүлж хэлэлцүүлэх эрхэй.
- 9.3 Удирдах зөвлөлийн гишүүн нь МЗХ-ны дэргэдэх байгууллагаас бусад салбар байгууллагын удирдлагаар хавсран ажиллаж болохгүй.



9.4 МЗХ-ны бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт багтсан төсөл хөтөлбөр санаачлах, удирдах, зохион байгуулах эрхтэй.

9.5 МЗХ-ны Удирдах зөвлөлийн гишүүнийг дараах үндэслэлээр чөлөөлнө. Үүнд:

- 9.5.1. Ерөнхийлөгч, Хяналтын зөвлөлөөс Удирдах зөвлөлийн гишүүнийг үүргийг хангалтгүй гүйцэтгэсэн гэж дүгнэсэн;
- 9.5.2. Чөлөөлөгдхөх хүсэлтээ өөрөө гаргасан;
- 9.5.3. Эрүүл мэндийн шалтгаанаар;
- 9.5.4. Нас барсан шалтгаанаар
- 9.5.5. Гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон;

Аравдугаар зүйл. Ерөнхий нарийн бичгийн даргын бүрэн эрх, үүрэг

10.1. МЗХ-ны ЕНБД нь гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэж, аль нэг байгууллагад ажил, албан тушаал хавсарч эрхлэхгүй. Улс төрийн намын гишүүнчлэлгүй байна.

10.2. МЗХ-ны ЕНБД нь ГХ-ны бүтцийн удирдлагуудыг Ерөнхийлөгчтэй зөвшилцэн томилж, чөлөөлнө.

10.3. МЗХ-ны ЕНБД нь батлагдсан бүтэц, төсвийн дагуу хүний нөөцийг томилж чөлөөлнө.

10.4. МЗХ-ны ЕНБД нь чөлөөлөгдөх хүсэлтээ Ерөнхийлөгчид бичгээр гаргана. Энэ тухай хүсэлтийг хүлээн авч УЗ-ийн зөвшөөрснөөр үүрэг гүйцэтгэгч томилно.

10.5. МЗХ-ны ЕНБД нь УЗ-ийн бодлого шийдвэрийг бүтэц, зөхион байгуулалт, хүний нөөц, санхүүгээр хангаж ГХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

10.6. МЗХ-ны ЕНБД нь ГХ-ны хурлыг даргална.

10.7. МЗХ-ны ЕНБД нь өмч хөрөнгө, татвар, санхүүжилтийг бүрэн хариуцна.

Арван нэгдүгээр зүйл. Гүйцэтгэх хорооны бүрэн эрх, үүрэг

11.1. МЗХ-ны ГХ нь ЕНБД газар, хэлтэс, албадаас бүрдэнэ.

11.2. ГХ-нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 11.2.1. УЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах;
- 11.2.2. МЗХ-ны үйл ажиллагааны төлөвлөгөө, жилийн төсвийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангаж ажиллах;
- 11.2.3. УЗ3 болон УЗ-ийн хурлын шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх;
- 11.2.4. МЗХ-ны бүтцийн байгууллагуудын ажлын уялдааг хангах, эрчимжүүлэх дүгнэх;
- 11.2.5. МЗХ-ны бүтцийн байгууллагуудыг шинээр байгуулах, шинэчлэх, өөрчлөн зохион байгуулах;
- 11.2.6. МЗХ-ны бүтцийн бүх шатны байгууллагуудын дүрмийг ёсчлох;
- 11.2.7. Хяналтын зөвлөлийн гаргасан дүгнэлтийг үндэслэн МЗХ-ны салбар нэгжийн хурлыг зарлан хуралдуулна.
- 11.2.8. Хуулиар хязгаарлаагүй бусад эрх;

Арван хоёрдугаар зүйл. Хяналтын зөвлөлийн бүрэн эрх, үүрэг

12.1. МЗХ-ны ХЗ нь өөрийн хяналтын сонгуульт байгууллага бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжийг удирдлага болгон энэхүү дүрэм, ХЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу үйл ажиллагаа явуулна.



12.2. МЗХ-ны Х3-ийн бүрэлдэхүүнийг МЗХ-ны ИХ-аас сонгох бөгөөд бүрэн эрхийн хугацаа 2 жил байна.

12.3. МЗХ-ны ИХ-ын чөлөөт цагт Х3-өөс орон гарвал ҮЗЗ-ийн хурлаас нөхөн томилно.

12.4. МЗХ-ны Х3 нь байнгын 5 гишүүнтэй байх ба Х3-ийн даргыг гишүүд нь дундаасаа нэр дэвшүүлж нууц санал хураалтаар сонгоно. Х3-ийн гишүүн нь МЗХ-ны бүтцийн бүх шатны байгууллагын сонгуульт гишүүний үргийг хавсрсан гүйцэтгэхгүй.

12.5. МЗХ-ны Х3-ийн гишүүн нь хараат бус байж, хуулийг дээдлэн гагцхүү МЗХ-ны Үндсэн дүрэмд захирагдана.

12.6. Х3-ийн гишүүн нь бүтцийн бүх шатны байгууллагын үйл ажиллагаанд хариуцлагыг сахиулах үүрэгтэй оролцох, МЗХ-ны Үндсэн дүрэм, түүнтэй холбогдон гарсан журам, ИХ, ҮЗЗ, УЗ, ГХ-ны шийдвэрийн биелэлтийг хангахыг шаардах бүрэн эрхтэй.

12.7. МЗХ-ны ИХ, ҮЗЗ, УЗ-ийн хурал нь Х3-ийн төлөөллийг оролцуулснаар хүчин төгөлдөрт тооцогдох бөгөөд Х3 нь тайлан, дүгнэлт хэлэлцүүлнэ.

12.8. МЗХ-ны Х3 нь дүгнэлт гаргах эрх бүхий дараах дэд хороодыг өргөтгөсөн бүрэлдэхүүнтэйгээр байгуулна. Үүнд:

12.8.1. Үйл ажиллагааны хяналтын дэд зөвлөл;

12.8.2. Санхүүгийн хяналтын дэд зөвлөл;

12.8.3. Ёс зүйн хяналтын дэд зөвлөл;

12.9. МЗХ-ны Х3 нь бүтцийн бүх шатны байгууллагуудын дэргэд хяналтын зөвлөл, байгууллагын 33-ийн дотор хариуцлага сахиулах дэг баригч гишүүнтэй байна.

12.10. МЗХ-ны Х3 нь үйл ажиллагааныхаа журмыг энэхүү дүрэмд нийцүүлэн боловсруулж ҮЗЗ-өөр батлуулна.

12.11. Хяналтын зөвлөлийн бүрэн эрх

12.11.1. МЗХ-ны Үндсэн дүрэм зөрчсөн талаар гишүүнээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;

12.11.2. МЗХ-ны Үндсэн дүрэм зөрчсөн талаар МЗХ-ны удирдах бүрэлдэхүүнээс гаргасан өргөдлийг хянан шийдвэрлэх;

12.11.3. МЗХ-ны сонгуульт гишүүн болон идэвхтэн гишүүн ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар дүгнэлт гаргах;

12.11.4. ИХ-аас бусад МЗХ-ны бүтцийн бүх шатны байгууллагын шийдвэр нь МЗХ-ны дүрэм зөрчсөн талаар журмаар үүсгэсэн маргааныг хянан шийдвэрлэх;

12.11.5. Бүтцийн бүх шатны байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэх, санхүүгийн үйл ажиллагаа, батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавих, хөндлөнгийн хяналт шалгалт оруулах;

12.11.6. Ээлжит бус ИХ-ыг хуралдуулах саналыг ҮЗЗ, УЗ-д оруулах;

12.11.7. МЗХ-ны үйл ажиллагааны тайлан, баримт бичигтэй танилцаж дүгнэлт гарах;

12.11.8. Цаг хугацааны болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар ҮЗЗ-ийн зарим эрх, УЗ-д шилжих нөхцөл үүссэнийг тогтоох;

12.11.9. Бүтцийн бүх шатны байгууллагын хяналтын зөвлөлөөс давсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

12.11.10. МЗХ-ны өмч хөрөнгийн ашиглалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих.



- 12.12. МЗХ-ны Х3-ийн шийдвэр гарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд МЗХ-ны Үндсэн дүрэм зөрчсөн шийдвэр, үйлдлийг давж үйлчилнэ.
- 12.13. МЗХ-ны Х3 нь аливаа маргааныг шийдвэрлэхдээ мэтгэлцэх, хөндлөнгийн байр сууринаас, шударга ёсыг эрхэмлэж МЗХ-ны Үндсэн дүрмийг сахиулна.
- 12.14. МЗХ-ны Х3 нь аливаа маргааныг шийдвэрлэх худалдаанд хоёр талын нэг нь төлөөлөгчөө хүндэтгэх бус шалтгаанаар ирүүлээгүй гэж үзвэл төлөөлөгчөө ирүүлсэн талын оролцоотойгоор шийдвэрлэх, талууд төлөөллөө ирүүлээгүй бол маргааныг хэрэгсэхгүй болгох эрхтэй.
- 12.15. МЗХ-ны Х3-ийн нийт сонгуульт гишүүдийн хариуцлагыг сахиулах ажлыг ИХ-ын өмнөөс Ерөнхийлөгчийн өмнө бүрэн хариуцна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

САЛБАР НЭГЖҮҮД

Монголын залуучуудын холбоо, түүний харьяа холбоо, хороо, зөвлөл, клуб, сан, дэргэдэх байгууллагуудыг холбооны салбар нэгж буюу бүтцийн байгууллага гэж үзнэ.

Арван гуравдугаар зүйл. Залуучуудын асуудал хариуцсан байнгын хороо

13.1. Залуучуудын асуудал хариуцсан байнгын хороо (цаашид БХ гэх) нь залуучуудын асуудлаар бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хангуулах, МЗХ-ны ҮЗЗ-ийн байнгын байгууллага мөн.

13.1.1 МЗХ-ны Байнгын хороодын тоо, удирдлага, хариуцсан асуудлыг МЗХ-ны УЗ-өөс тогтоож батална.

13.2. МЗХ-ны БХ нь сард нэгээс доошгүй хуралдана. Шаардлагатай тохиолдолд МЗХ-ны Ерөнхийлөгч, УЗ-ийн санаачилгаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

13.3. БХ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

13.3.1. БХ-ны тайлан, илтгэлийг сонсож хэлэлцэх

13.3.2. Шаардлагатай тохиолдолд БХ-ны тэргүүлэгчдийн олонхын саналаар БХ-ны дарга, гишүүнийг Ерөнхийлөгчтэй зөвшилцэн сонгох, чөлөөлөх;

13.3.3. БХ-ны дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, тэргүүлэгчид гэсэн нийт 9 хүний удирдах бүрэлдэхүүн, гишүүдээс бүрдэнэ. Удирдах бүрэлдэхүүн нь ҮЗЗ-ийн гишүүдээс бүрдэнэ.

13.3.4. БХ-ны тэргүүлэгчдийн олонхын саналаар БХ хурлыг зарлан хуралдуулах;

13.3.5. МЗХ-ны Үндсэн дүрэмд нийцүүлэн БХ-ны журмыг боловсруулна. Журмыг МЗХ-ны Ерөнхийлөгч батална.

13.3.6. БХ-ны үйл ажиллагааг дэмжих дэд хороо, клуб, сан, сургалтын байгууллагатай байж болно.

13.2. БХ-ны даргын бүрэн эрх

13.2.1 Байнгын хорооны дарга нь МЗХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн байна.

13.2.2. Залуучуудын талаарх асуудлаар хорооны тэргүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах, хорооны хурлыг даргалах, хорооны хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг батлах;

13.2.3. Залуучуудын талаарх асуудлаар МЗХ-ны Ерөнхийлөгчтэй хорооны тэргүүлэгч гишүүдийг төлөөлөн зөвлөлдөх хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг батлуулах, хорооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлант хариуцах;



13.2.4. Залуучуудын асуудлаар бодлого боловсруулах ажлын хэсэг байгуулах, ажлын хэсгийг удирдах, бодлого чиглэлээр хангах;

13.3. БХ-ны тэргүүлэгчдийн бүрэн эрх

13.3.1. БХ-ны даргыг хорооны хурлаар сонгох, хорооны үйл ажиллагааны бодлого чиглэлийг тодорхойлох, төлөвлөгөөг батлах;

13.3.2. Хорооны бүтэц, зохион байгуулалтыг батлах, түүний биелэлтийг хянах, ажлын тайлан, мэдээллийг сонсож хэлэлцэх.

Арван дөрөвдүгээр зүйл. Аймгийн залуучуудын холбоо

14.1. МЗХ-ны Аймгийн Залуучуудын Холбооны (АЗХ) чуулган нь /цаашид "чуулган" гэх/ аймгийн Залуучуудын Холбооны удирдах байгууллага мөн.

14.2. Ээлжит чуулган нь 2 жилд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус чуулганыг ХЗ-ийн саналаар тэргүүн зарлан хуралдуулж болно.

14.3. Чуулган нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

14.3.1. АЗХ-ны дүрмийг МЗХ-ны Үндсэн дүрмийн хүрээнд бүтцийг хадгалан батлах, ГХ дүрмийг ёсчлох;

14.3.2. ИХ, ҮЗЗ, УЗ, ГХ-ноос гаргасан шийдвэрийг аймгийн түвшинд хэрэгжүүлэх шийдлийг тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

14.3.3. АЗХ-ны тэргүүнийг сонгох, чөлөөлөх;

14.3.4. АЗХ-ны тэргүүлэгчдийг 17-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэй сонгох, чөлөөлөх;

14.3.5. АЗХ-ны Тэргүүн, тэргүүлэгчдийн тайлан, илтгэлийг хэлэлцэх;

14.3.6. АЗХ-ны хяналтын зөвлөлийн тайлан, илтгэлийг хэлэлцэх;

14.3.7. МЗХ-ны ХЗ-ийн салбар хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах;

14.3.8. АЗХ-ны чуулганы чөлөөт цагт ажиллах Аймгийн Залуучуудын Бага чуулганыг байгуулах;

14.4. Аймгийн Залуучуудын Бага чуулган (цаашид бага чуулган) гэх нь АЗХ-ны тэргүүн, дэд тэргүүн, тэргүүлэгч гишүүд, ерөнхий санхүүч, үйл ажиллагаа, салбар хариуцсан нарийн бичгийн дарга нар, Сумын Холбооны тэргүүн, тэргүүлэгчид, аймгийн төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтан нар чөлөөт бус гишүүнээр сонгогдоно.

14.5. Бага чуулган нь жилд нэгээс доошгүй удаа хуралдана. АЗХ-ны тэргүүн эсвэл Бага чуулганы гишүүдийн олонхын саналаар ээлжит бус чуулганыг хуралдуулж болно.

14.6. Бага чуулганы нийт гишүүдийн суудлын тоо 119 байна. Жил бүр АЗХ-ны тогтоосон квотоор, тогтсон хугацаанд Бага чуулганы гишүүний эргэлтэд хамрагдах /ротаци/ сонгууль явагдана.

14.7. Бага чуулган нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

14.7.1. Шаардлагатай асуудлаар чуулганы чөлөөт цагт аймгийн залуучуудын холбооны бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох;

14.7.2. Олонхын саналаар бага чуулганыг товлон зарлах;

14.7.3. АЗХ-ны ажлын тайлан, төсөв төлөвлөгөөг хэлэлцэн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх;



- 14.7.4. Шаардлагатай тохиолдолд АЗХ-ны тэргүүлэгч гишүүдийн олонхын саналаар аймгийн залуучуудын холбооны тэргүүнийг МЗХ-ны Ерөнхийлөгчтэй зөвшилцэн чөлөөлөх, сонгох, томилох.
- 14.8. АЗХ-ны тэргүүлэгчид дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 14.8.1. Бага чуулганы хооронд холбооны бодлого үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлон хэрэгжүүлэх;
- 14.8.2. Бага чуулганы товлон зарлах;
- 14.8.3. АЗХ-ны бүтэц, зохион байгуулалтыг батлах, түүний биелэлтийг хянах, ажлын тайлан, мэдээллийг сонсож хэлэлцэх;
- 14.9. АЗХ-ны дэргэд хүсэл сонирхол, мэргэжлийн дагуу эвлэлдэн нэгдсэн клуб, байгууллагын залуучуудын зөвлөлтэй байж болно.
- 14.10. АЗХ-ны дэргэдэх байгууллага нь АЗХ-ны дүрэмд нийцүүлэн дэргэдэх байгууллагын дүрмийг боловсруулах бөгөөд дүрмийн хүрээнд ажиллана.
- 14.11. МЗХ-ны Улаанбаатар хот дахь Аймгийн Залуучуудын Холбооны (УБАЗХ) чуулган нь /цаашид “чуулган” гэх/ Улаанбаатар хот дахь Аймгийн Залуучуудын Холбооны удирдах байгууллага мөн.
- 14.12. МЗХ-ны УБАЗХ нь АЗХ-ны дэргэдэх байгууллага байна.
- 14.13. Ээлжит чуулган нь 2 жилд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус чуулганыг ХЗ-ийн саналаар тэргүүн зарлан хуралдуулж болно.
- 14.14. Чуулган нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 14.14.1. УБАЗХ-ны дүрмийг МЗХ-ны Үндсэн дүрмийн хүрээнд бүтцийг хадгалан батлах, ГХ дүрмийг ёсчлох;
- 14.14.2. ИХ, ҮЗЗ, ҮЗ, ГХ-ноос гаргасан шийдвэрийг аймгийн түвшинд хэрэгжүүлэх шийдлийг тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
- 14.14.3. УБАЗХ-ны тэргүүлэгчдийг 17-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэй сонгох, чөлөөлөх
- 14.14.4. УБАЗХ-ны Тэргүүн, тэргүүлэгчдийн тайлан, илтгэлийг хэлэлцэх;
- 14.14.5. УБАЗХ-ны хяналтын зөвлөлийн тайлан, илтгэлийг хэлэлцэх;
- 14.14.6. ХЗ-ийн салбар хяналтын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах;
- 14.14.7. УБАЗХ-ны чуулганы чөлөөт цагт ажиллах Улаанбаатар хот дахь Аймгийн Залуучуудын Зөвлөлийг байгуулах.
- 14.15. МЗХ-ны Улаанбаатар хот дахь Аймгийн Залуучуудын Бага чуулган (цаашид УБАЗХ гэх) нь УБАЗХ-ны тэргүүн, дэд тэргүүн, тэргүүлэгч гишүүд, ерөнхий санхүүч, үйл ажиллагаа, салбар хариуцсан нарийн бичгийн дарга нар, Сумын ЗХ-ны тэргүүн, аймгийн төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтан нар чөлөөт бус гишүүнээр сонгогдоно.
- 14.16. УБАЗБЧ нь жилд нэгзэс доошгүй удаа хуралдана. УБАЗХ-ны тэргүүн эсвэл УБАЗБЧ-ны тэргүүлэгч гишүүдийн олонхын саналаар ээлжит бус чуулганыг хуралдуулж болно.
- 14.17. УБАЗБЧ-ны нийт гишүүдийн суудлын тоо 119 байна. Жил бүр УБАЗХ-ны тогтоосон квотоор, тогтсон хугацаанд УБАЗБЧ-ны гишүүний эргэлтэнд хамрагдах /ротаци/ сонгууль явагдана.
- 14.18. Улаанбаатар хот дахь Аймгийн Залуучуудын Бага чуулган нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:



- 14.18.1. Шаардлагатай асуудлаар чуулганы чөлөө цагт аймгийн залуучуудын холбооны бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох;
 - 14.18.2. УБАЗ бага чуулганыг товлон зарлах;
 - 14.18.3. УБАЗХ-ны ажлын тайлан, төсөв төлөвлөгөөг хэлэлцэн батлах, үйл ажиллагаанд дүгнэлт өгөх;
 - 14.18.4. Шаардлагатай тохиолдолд УБАЗХ-ны тэргүүлэгч гишүүдийн олонхын саналаар УБАЗХ-ны тэргүүнийг МЗХ-ны Ерөнхийлөгчтэй зөвшилцэн чөлөөлөх, сонгох, томилох;
- 14.19. УБАЗХ-ны тэргүүлэгчид дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 14.19.1. УБАЗБЧ-ны хурлын хооронд холбооны бодлого үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлон хэрэгжүүлэх;
 - 14.19.2. Олонхын саналаар УБАЗБЧ-ны хурлыг товлон зарлах;
 - 14.19.3. УБАЗХ-ны бүтэц, зохион байгуулалтыг батлах, түүний биелэлтийг хянах, ажлын тайлан, мэдээллийг сонсож хэлэлцэх;
- 14.20. УБАЗХ-ны дэргэд хүсэл сонирхол, мэргэжлийн дагуу эвлэлдэн нэгдсэн клуб, байгууллагын залуучуудын зөвлөлтэй байж болно.
- 14.21. УБАЗХ-ны дэргэдэх байгууллага нь УБАЗХ-ны дүрэмд нийцүүлэн дэргэдэх байгууллагын дүрмийг боловсруулах бөгөөд дүрмийн хүрээнд ажиллана.

Арван тавдугаар зүйл. Дүүргийн Залуучуудын холбоо

- 15.1. Дүүргийн залуучуудын холбооны чуулган нь (цаашид “чуулган” гэх) дүүргийн залуучуудын холбооны удирдах байгууллага мөн.
- 15.2. Ээлжит чуулган нь 2 жилд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус чуулганыг ХЗ-ийн саналаар тэргүүн зарлан хуралдуулж болно.
- 15.3. Чуулган дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 15.3.1. ДЗХ-ны дүрмийг МЗХ-ны Үндсэн дүрмийн хүрээнд бүтцийг хадгалан батлах, Дүрмийг ГХ ёсчлох;
 - 15.3.2. ИХ, ҮЗЗ, ҮЗ, ГХ-ноос гаргасан шийдвэрийг дүүргийн түвшинд хэрэгжүүлэх шийдлийг тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
 - 15.3.3. ДЗХ”ны тэргүүнийг сонгох, чөлөөлөх;
 - 15.3.4. ДЗХ-ны тэргүүлэгчдийг 17-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэй сонгох, чөлөөлөх;
 - 15.3.5. ДЗХ-ны тэргүүн, тэргүүлэгчдийн тайлан, илтгэлийг хэлэлцэх;
 - 15.3.6. ДЗХ-ны хяналтын зөвлөлтйн тайлан, илтгэлийг хэлэлцэх;
 - 15.3.7. ХЗ-ийн дүүргийн салбар Хяналтын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах;
 - 15.3.8. ДЗХ-ны чөлөөт цагт ажиллах Дүүргийн залуучуудын бага чуулганыг байгуулах.
- 15.4. Дүүргийн Залуучуудын бага чуулган (цаашид “Бага чуулган” гэх) нь ДЗХ-ны тэргүүн, дэд тэргүүн, тэргүүлэгч гишүүд, ерөнхий санхүүч, үйл ажиллагаа, салбар хариуцсан нарийн бичгийн дарга нар, Хорооны ЗХ-ны тэргүүн, дүүргийн төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтан нар чөлөөт бус гишүүнээс сонгогдоно.



15.5. Бага чуулган нь жилд 1-ээс доошгүй удаа хуралдана. ДЗХ-ны тэргүүн эсвэл тэргүүлэгч гишүүдийн олонхын саналаар бага чуулганыг зэлжит бус чуулганыг хуралдуулж болно.

15.6. Бага чуулганы нийт гишүүдийн суудлын тоо 119 байна. Жил бүр ДЗХ-ны тогтоосон квотоор, тогтсон хугацаанд Бага чуулганы гишүүний эргэлтэд хамрагдах /ротаци/ сонгууль явагдана.

15.7. Бага чуулган дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

15.7.1. Шаардлагатай асуудлаар чуулганы чөлөөт цагт ДЗХ-ны бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох;

15.7.2. Бага чуулганыг товлон зарлах;

15.7.3. ДЗХ-ны ажлын тайлан, төсөв төлөвлөгөөг хэлэлцэн батлах, үйл ажиллагаанд дүгнэлт өгөх;

15.7.4. Шаардлагатай тохиолдолд ДЗХ-ны тэргүүлэгч гишүүдийн олонхоор, ДЗХ-ны тэргүүнийг МЗХ-ны Ерөнхийлөгчтэй зөвшилцэн чөлөөлөх, сонгох, томилох;

15.8. ДЗХ-ны тэргүүлэгчид дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

15.8.1. Бага чуулганы хороонд ДЗХ-ны үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлон хэрэгжүүлэх;

15.8.2. Олонхын саналаар бага чуулганы хурлыг товлон зарлах;

15.8.3. ДЗХ-ны бүтэц зохион байгуулалтыг батлах, түүний биелэлтийг хянах, ажлын тайлан, мэдээллийг сонсож хэлэлцэх;

15.8.4. ДЗХ-ны дэргэд хүсэл сонирхол, мэргэжлийн дагуу эвлэлдэн нэгдсэн клуб, байгууллагын залуучуудын зөвлөлтэй байж болно.

15.9. ДЗХ-ны дэргэдэх байгууллага нь ДЗХ-ны дүрэмд нийцүүлэн дэргэдэх байгууллагын дүрмийг боловсруулах бөгөөд дүрмийн хүрээнд ажиллана.

Арван зургадугаар зүйл. Чиглэлийн Залуучуудын холбоо

16.1. Чиглэлийн залуучуудын холбооны чуулган нь (цаашид “чуулган” гэх) чиглэлийн залуучуудын холбооны удирдах байгууллага мөн.

16.2. Ээлжит чуулган нь 2 жилд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус чуулганыг ХЗ-ийн саналаар тэргүүн зарлан хуралдуулж болно.

16.3. Чуулган дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

16.3.1. ЧЗХ-ны бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох;

16.3.2. ЧЗХ-ны тэргүүн, тэргүүлэгчдийн тайлан, илтгэлийг хэлэлцэх;

16.3.3. ЧЗХ-ны хяналтын зөвлөлийн тайлан, илтгэлийг хэлэлцэх;

16.3.4. ЧЗХ-ны тэргүүн, тэргүүлэгчдийг 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй сонгох, чөлөөлөх;

16.3.5. ХЗ-ийн салбар Хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах;

16.3.6. ЧЗХ-ны удирдах бүрэлдэхүүнийг байгуулах;

16.3.7. Энэхүү дүрэмд нийцүүлэн ЧЗХ-ны дүрмийг боловсруулна. Дүрмийг ГХ ёсчилох.



16.4. ЧЗХ-ны удирдах бүрэлдэхүүн нь (цаашид "удирдах бүрэлдэхүүн" гэх) ЧЗХ-ны тэргүүн, тэргүүлэгч гишүүд, хяналтын зөвлөл, салбарын төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтан нараас бүрдэнэ.

16.5. Удирдах бүрэлдэхүүн нь жилд 2-оос доошгүй удаа хуралдана. ЧЗХ-ны тэргүүн эсвэл удирдах бүрэлдэхүүний гишүүдийн олонхын саналаар ЧЗХ-ны ээлжит бус чуулганыг хуралдуулж болно.

16.6. Удирдах бүрэлдэхүүн нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

16.6.1. Шаардлагатай асуудлаар чуулганы чөлөөт цагт ЧЗХ-ны бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох;

16.6.2. ЧЗХ-ны чуулганыг товлон зарлах;

16.6.3. ЧЗХ-ны ажлын тайлан, төсөв төлөвлөгөөг хэлэлцэн батлах, үйл ажиллагаанд дүгнэлт өгөх;

16.6.4. Шаардлагатай тохиолдолд ЧЗХ-ны тэргүүлэгч гишүүдийн олонхын саналаар ЧЗХ-ны тэргүүнийг МЗХ-ны Ерөнхийлөгчтэй зөвшилцэн чөлөөлөх, сонгох, томилох;

16.7. ЧЗХ-ны тэргүүлэгчид дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

16.7.1. Удирдах бүрэлдэхүүний хурлын хооронд ЧЗХ-ны үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлон хэрэгжүүлэх;

16.7.2. Олонхын саналаар удирдах бүрэлдэхүүний хурлыг товлон зарлах;

16.7.3. ЧЗХ-ны бүтэц, зохион байгуулалтыг батлах, түүний биелэлтийг хянах, ажлын тайлан, мэдээллийг сонсож хэлэлцэх;

16.8. ЧЗХ-ны дэргэд хүсэл сонирхол, мэргэжлийг дагуу эвлэлдэн нэгдсэн клуб, байгууллагын залуучуудын зөвлөлтэй байж болно.

16.9. ЧЗХ-ны дэргэдэх байгууллага нь ЧЗХ-ны дүрэмд нийцүүлэн дэргэдэх байгууллагын дүрмийг боловсруулах бөгөөд дүрмийн хүрээнд ажиллана.

Арван долдугаар зүйл. Сумын залуучуудын холбоо

17.1. Сумын залуучуудын холбооны хурал нь (цаашид "хурал" гэх) СЗХ-ны өөрөө удирдах байгууллага мөн.

17.2. Ээлжит хурал нь жилд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд зэлжит бус хурлыг ХЗ-ийн саналаар тэргүүн зарлан хуралдуулж болно.

17.3. Хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

17.3.1. СЗХ-ны тайлан, илтгэлийг сонсож хэлэлцэх;

17.3.2. СЗХ-ны тэргүүлэгчдийг 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй сонгох чөлөөлөх;

17.3.3. ХЗ-ийн сумын салбар Хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах;

17.3.4. СЗХ-ны тэргүүлэгчдийн олонхын саналаар СЗХ-ны хурлыг зарлан хуралдуулах;

17.3.5. Энэхүү дүрэмд нийцүүлэн СЗХ-ны дүрмийг боловсруулна. Дүрмийг дээд шатны байгууллага ёсчлох;

17.3.6. СЗХ-ны дэргэд хүсэл сонирхол, мэргэжлийн дагуу эвлэлдэн нэгдсэн клуб, байгууллагын залуучуудын зөвлөлтэй байж болно.



17.3.7. СЗХ-ны дэргэдэх байгууллага нь СЗХ-ны дүрэмд нийцүүлэн дэргэдэх байгууллагын дүрмийг боловсруулах бөгөөд дүрмийн хүрээнд ажиллана;

17.3.8. Бусад асуудал.

Арван наймдугаар зүйл. МЗХ-ны Хорооны залуучуудын холбоо

18.1. Хорооны залуучуудын холбооны хурал нь (цаашид “хурал” гэх) ХЗХ-ны өөрөө удирдах байгууллага мөн.

18.2. Ээлжит хурал нь жилд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг ХЗ-ийн саналаар тэргүүн зарлан хуралдуулж болно.

18.3. Хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

18.3.1. ХЗХ-ны тайлан илтгэлийг сонсож хэлэлцэх;

18.3.2. ХЗХ-ны тэргүүлэгчдийг 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй сонгох, чөлөөлөх;

18.3.3. ХЗ-ийн Хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах;

18.3.4. ХЗХ-ны тэргүүлэгчдийн олонхын саналаар ХЗХ-ны хурлыг зарлан хуралдуулна.

18.3.5. Энэхүү дүрэмд нийцүүлэн ХЗХ-ны дүрмийг боловсруулна. Дүрмийг дээд шатны байгууллага ёсчлох;

18.3.6 ХЗХ-ны дэргэд хүсэл сонирхол, мэргэжлийн дагуу эвлэлдэн нэгдсэн клуб, байгууллагын залуучуудын зөвлөлтэй байж болно.

18.3.7. ХЗХ-ны дэргэдэх байгууллага нь ХЗХ-ны дүрэмд нийцүүлэн дэргэдэх байгууллагын дүрмийг боловсруулах бөгөөд дүрмийн хүрээнд ажиллана;

18.3.8. Бусад асуудал;

Арван есдүгээр зүйл. МЗХ-ны Багийн залуучуудын зөвлөл

19.1. Багийн залуучуудын зөвлөлийн хурал нь (цаашид “хурал” гэх) Ба33-ийн өөрөө удирдах байгууллага мөн.

19.2. Ээлжит хурал нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг ХЗ-ийн саналаар тэргүүн зарлан хуралдуулж болно.

19.3. Хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

19.3.1. Ба33-ийн тайлан илтгэлийг сонсож хэлэлцэх;

19.3.2. Ба33-ийн тэргүүлэгчдийг 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй сонгох, чөлөөлөх;

19.3.3. ХЗ-ийн салбар Хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах;

19.3.4. Ба33-ийн тэргүүлэгчдийн 2/3-ын саналаар Ба33-ийн хурлыг зарлан хуралдуулах;

19.3.5. Энэхүү дүрэмд нийцүүлэн Ба33-ийн дүрмийг боловсруулна. Дүрмийг дээд шатны байгууллага ёсчлох.

19.3.6. Ба33-ийн дэргэд хүсэл сонирхол, мэргэжлийн дагуу эвлэлдэн нэгдсэн клуб, байгууллагын залуучуудын зөвлөлтэй байж болно.

19.3.7. Ба33-ийн дэргэдэх байгууллага нь БА33-ийн дүрэмд нийцүүлэн дэргэдэх байгууллагын дүрмийн боловсруулах бөгөөд дүрмийн хүрээнд ажиллана.

19.3.8. Бусад асуудал.



Хорьдугаар зүйл. МЗХ-ны Хэсгийн залуучуудын зөвлөл

- 20.1. Хэсгийн залуучуудын зөвлөлийн хурал нь (цаашид “хурал” гэх) Хэ33-ийн өөрөө удирдах байгууллага мөн.
- 20.2. Ээлжит хурал нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг Х3-ийн саналаар тэргүүн зарлан хуралдуулж болно.
- 20.3. Хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 20.3.1. Хэ33-ийн тайлан илтгэлийг сонсож хэлэлцэх;
 - 20.3.2. Хэ33-ийн тэргүүлэгчдийг 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй сонгох, чөлөөлөх;
 - 20.3.3. Х3-ийн салбар Хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах;
 - 20.3.4. Хэ33-ийн тэргүүлэгчдийн 2/3-ын саналаар Хэ33-ийн хурлыг зарлан хуралдуулах;
 - 20.3.5. Энэхүү дүрэмд нийцүүлэн Хэ33-ийн дүрмийг боловсруулна. Дүрмийг дээд шатны байгууллага ёсчлох.
 - 20.3.6. Хэ33-ийн дэргэд хүсэл сонирхол, мэргэжлийн дагуу эвлэлдэн нэгдсэн клуб, байгууллагын залуучуудын зөвлөлтэй байж болно.
 - 20.3.7. Хэ33-ийн дэргэдэх байгууллага нь Хэ33-ийн дүрэмд нийцүүлэн дэргэдэх байгууллагын дүрмийн боловсруулах бөгөөд дүрмийн хүрээнд ажиллана.
 - 20.3.8. Бусад асуудал.

Хорин нэгдүгээр зүйл. МЗХ-ны Байгууллагын залуучуудын зөвлөл

- 21.1. Байгууллагын залуучуудын зөвлөлийн хурал нь (цаашид “хурал” гэх) Б33-ийн өөрөө удирдах байгууллага мөн.
- 21.2. Ээлжит хурал нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг Х3-ийн саналаар тэргүүн зарлан хуралдуулж болно.
- 21.3. Хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 21.3.1. Б33-ийн тайлан илтгэлийг сонсож хэлэлцэх;
 - 21.3.2. Б33-ийн тэргүүлэгчдийг 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй сонгох, чөлөөлөх;
 - 21.3.3. Х3-ийн салбар Хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах;
 - 21.3.4. Б33-ийн тэргүүлэгчдийн 2/3-ын саналаар Б33-ийн хурлыг зарлан хуралдуулах;
 - 21.3.5. Энэхүү дүрэмд нийцүүлэн Б33-ийн дүрмийг боловсруулна. Дүрмийг дээд шатны байгууллага ёсчлох.
 - 21.3.6. Б33-ийн дэргэд хүсэл сонирхол, мэргэжлийн дагуу эвлэлдэн нэгдсэн клуб, байгууллагын залуучуудын зөвлөлтэй байж болно.
 - 21.3.7. Б33-ийн дэргэдэх байгууллага нь Б33-ийн дүрэмд нийцүүлэн дэргэдэх байгууллагын дүрмийн боловсруулах бөгөөд дүрмийн хүрээнд ажиллана.
 - 21.3.8. Бусад асуудал.

Хорин хоёрдугаар зүйл. МЗХ-ны дэргэдэх байгууллага



22.1. МЗХ-ны дэргэдэх байгууллага нь цаашид дэргэдэх байгууллага гэх нь хүсэл сонирхол, мэргэжлийн дагуу эвлэлдэн нэгдсэн клуб, дугуйлан, сургалт, судалгааны төв, корпорац, сан байна.

22.2. Үүсгэн байгуулсан дээд шатны залуучуудын байгууллагаас гаргасан аливаа санал санаачилгыг байнга үйл ажиллагаанд тусгаж ажиллана.

22.3. Дэргэдэх байгууллага нь энэхүү дүрэм журамд нийцүүлэн ажиллана.

22.4. Энэхүү дүрэмд нийцүүлэн дэргэдэх байгууллагын дүрмийг боловсруулна. Дүрмийг дээд шатны байгууллага ёсчилно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГИШҮҮНЧЛЭЛ

Хорин гуравдугаар зүйл. Гишүүнчлэл

23.1. Монгол улсын иргэн 16-40 нас хүртэлх залуу хүнийг МЗХ-ны энгийн гишүүн гэж үзнэ.

23.2. МЗХ-ны бүтцийн бүх шатны байгууллагын үнэмлэхтэй гишүүнийг идэвхтэн гишүүн гэж үзнэ.

23.3. МЗХ-ны ИХ, УЗ болон бүх шатны залуучуудын байгууллагын тэргүүн, тэргүүлэгч гишүүдийг МЗХ-ны сонгуульт гишүүн гэж үзнэ.

23.4. Сонгуульт гишүүн нь МЗХ-ны бүтцийн бүх шатны байгууллагад сонгуульт албан тушаалыг энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол хавсрان гүйцэтгэхгүй.

23.5. Сонгуульт гишүүний насны хязгаар энэхүү дүрмийн 23.1 дэх заалтад зааснаас хэтэрсэн нь бүрэн эрхийн хугацаа дуусгавар болгох үндэслэл болохгүй.

Хорин дөрөвдүгээр зүйл. Гишүүний эрх

24.1. МЗХ-ны үйл ажиллагаанд тэгш эрхтэйгээр оролцох, харьяалагдах салбар холбоод, залуучуудын зөвлөлийнхөө хэлэлцэж буй асуудлуудад санал өгөх.

24.2. МЗХ-ны удирдлага, бусад албан тушаалд өөрийн болон бусдын нэрийг дэвшүүлэх, сонгох, сонгогдох, томилогдон ажиллах, өөрийн хүсэлтээр ажиллахаас татгалзах.

24.3. МЗХ-ны талаар санал хүсэлтээ илэрхийлэх, гомдол гаргах, шийдвэрлүүлэх.

24.4. Монгол Улсын Үндсэн Хууль, бусад хууль, МЗХ-ны Үндсэн дүрэмд болон бусад журамд харшлаагүй тохиолдолд үзэл бодол, нэр төрийн хувьд холбооны өмгөөлөл, ивээлд багтах.

24.5. МЗХ-ны удирдлага нь гишүүдийн нийтлэг эрх ашигт нийцээгүй шийдвэр гаргасан, үйл ажиллагаа явуулсан гэж үзвэл харьяалагдах салбар холбоо, залуучуудын зөвлөлийнхөө харьяалагдах Хяналтын зөвлөлд хандаж хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

24.6. МЗХ-ны бүтцийн бүх шатны байгууллага нь гишүүдийнхээ нийтлэг эрх ашигт нийцээгүй шийдвэр гаргасан, үйл ажиллагаа явуулсан гэж үзвэл дээд шатны байгууллагынхаа Хяналтын зөвлөлд хандан хэлэлцэн шийдвэрлүүлэх.

24.7. МЗХ, салбар холбоо, залуучуудын зөвлөлийн бодлого, үйл ажиллагаа, санхүүжилттэй холбоотой мэдээлэл чөлөөтэй авах.

24.8. МЗХ-ны үзэл баримтлал, мэрийн хөтөлбөр, бодлого боловсруулах, хэлэлцэхэд болон холбооноос хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, явуулж буй үйл ажиллагаанд оролцох.

24.9. МЗХ шат шатны хуралд өөрийнх нь тухай хэлэлцэхэд биечлэн оролцохыг шаардах.



24.10. Гадаадад амьдарч байгаа холбооны гишүүд, дэмжигчид холбооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор нэгдэх.

Хорин тавдугаар зүйл. Гишүүний үүрэг

25.1. МЗХ-ны үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлэх, МЗХ-ны Үндсэн дүрэм болон түүнд нийцүүлэн гаргасан бусад журам, шийдвэрийг даган мөрдөх.

25.2. МЗХ-ны гишүүн нь залуучуудын байгууллагынхаа нэр хүндийг дээдлэн дэлгэрүүлнэ.

25.3. МЗХ-ны гишүүд, дэмжигчдийн хүрээг өргөтгөх, холбоог бэхжүүлэхэд идэвх санаачилга гаргах.

25.3.1. МЗХ-ны зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;

25.3.2. Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас МЗХ-нд учруулсан хохирлыг нөхөн төлөх;

Хорин зургаадугаар зүйл. Гишүүнээс түдгэлзэх, чөлөөлөгдөх

26.1. МЗХ-ны идэвхтэн, сонгуульт гишүүн хууль тогтоомжид заасан үндэслэл, өөрийн хүсэлтээр гишүүнээр түдгэлзэх бөгөөд энэ тухайгаа харьяалах шатны залуучуудын байгууллагад албан журмаар мэдэгдэж бүртгүүлнэ. Энэхүү заалт нь энгийн гишүүдэд хамаарахгүй.

26.2. Идэвхтэн сонгуульт гишүүн холбооноос чөлөөлөгдөх хүсэлтээ харьяалагдах салбар холбоо, залуучуудын зөвлөлдөө мэдүүлснээс хойш 30 хоногийн дотор гишүүнийг МЗХ-ны бүртгэлээс зөвлөлдөө мэдүүлснээс хойш 30 хоногийн дотор гишүүнийг МЗХ-ны бүртгэлээс хасуулахыг тухайн харьяалагдах салбар холбоо, зөвлөл хариуцна.

26.3. Гишүүн нь холбооноос гарах хүсэлтийнхээ хамт гишүүний үнэмлэхээ хүчингүй тооцуулж хадгалж болно.

26.4. Хэрэв дээрх 26.1 дахь заалт 26.2-т заасан хугацаанд хэрэгжүүлээгүй бол идэвхтэн, сонгуульт гишүүнээс чөлөөлөгдсөнд тооцно.

Хорин долдугаар зүйл. Гишүүний татвар, хандив, санхүүжилт

27.1. Идэвхтэн, сонгуульт гишүүний татварын хэмжээг журмаар тогтооно. Тогтоосон хэмжээнээс хэтэрсэн татвар, эд зүйлс, мөнгийг идэвхтэн гишүүн, сонгуульт гишүүнээс шаардахыг хориглоно.

27.1.1. Дор дурдсан этгээд дараах хуралдаанд оролцохдоо томилолтын зардлаа өөрөө хариуцна.

27.1.1.1. ҮЗ33 буюу ХЗ-ийн гишүүн Их хурлын болон ҮЗ33-ийн хуралдаанд

27.1.1.2. Их хурлын төлөөлөгч, өөрөөр шийдвэрлээгүй бол Их хурлын хуралдаанд;

27.1.2. Бүх шатны залуучуудын байгууллагын сонгуульт гишүүн татвараа тухайн жилийн 2 дугаар сарын 1-нээс өмнө бүрэн төлсөн байна.

27.1.3. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас татварын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг харьяалагдах Хяналтын зөвлөл шийдвэрлэнэ. Зөвлөлийн шийдвэр нь тодорхой гишүүнд давуу байдал олгоогүй байна.

27.1.4. Гишүүний татвараас илүү өгсөн эд зүйлийн болон мөнгөн хөрөнгийг хандивт тооцно.

Хорин наймдугаар зүйл. Гишүүнд олгох шагнал, урамшуулал



28.1. МЗХ-ны удирдлага нь гишүүнээ харьялагдах салбар холбоо, хороо, залуучуудын зөвлөл, дэргэдэх байгууллагын тодорхойлолтод үндэслэн дээд шатны байгууллага, төр засгийн шагналд тодорхойлох бас холбооны шагнал урамшуулал олгоно.

28.2. Шагнал, урамшууллын төрөл;

28.2.1 Төрийн шагнал, одон, медальд тодорхойлох;

28.2.2. Холбооны од, медалиар шагнах;

28.2.3. Бусад төрлийн шагнал, урамшуулал;

Хорин есдүгээр зүйл. Сонгуульт гишүүнд шийтгэл ногдуулах, эргүүлэн татах

29.1. Сонгуульт гишүүн нь ёс зүйн алдаа гаргасан, сонгуульт гишүүний үүргээ биелүүлээгүй болон МЗХ-ны Үндсэн дүрмийг зөрчсөн үйлдэл нь 3-аас дээш давтагдсан тохиолдолд дүрмийн дагуу Х3, Салбар Х3-ийн дүгнэлтийг үндэслэн дараах шийтгэлийн аль нэгийг зохих шатны холбооны удирдлага ногдуулна. Үүнд:

29.1.1. Сануулах:

29.1.2. МЗХ-ны сонгуульт албан тушаалаас огцруулах:

29.1.3. Сонгуульт албан тушаалтан авилга хээл хахуулттай холбоотой нэр хүнд нь холбогдсон тохиолдолд сонгуульт албан тушаалыг сайн дураараа өгөх, албан тушаал хা�ших эрхийг түдгэлзүүлнэ;

29.1.4. МЗХ болон салбар холбоо, хороо, залуучуудын зөвлөлийн тэргүүн, тэргүүлэгч гишүүний албан тушаалд, ИХ, Y33, салбар холбоо, хороо, залуучуудын зөвлөлд 4 жил хүртэлх хугацаагаар нэр дэвшүүлэхгүй байх;

29.1.5. УИХ, аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороо, багийн иргэдийн хуралд нэр дэвшихэд улс төр, нийгэм, эдийн засаг, бизнесийн салбарт бүхий л талаар дэмжин ажиллахгүй:

29.1.6. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татвараа хугацаанд нь төлөөгүй тохиолдолд сонгуульт гишүүний бүрэн эрх дуусгавар болсонд тооцно.

29.1.7. Бүтцийн бүх шатны сонгуульт гишүүн нь харьялагдах Х3 болон салбар Х3-өөр хариуцлага тооцуулсан бол гишүүний бүрэн эрх дуусгавар болох үндэслэл болно.

Гучдугаар зүйл. Идэвхтэн, сонгуульт гишүүнийг дэмжих

30.1. МЗХ-ны идэвхтэн, сонгуульт гишүүн нь тухайн жилийнхээ татварыг хугацаанд төлснөөр харьялагдах шатны залуучуудын байгууллагын хурал, чуулганд саналын эрхтэй оролцено.

30.2. Идэвхтэн, сонгуульт гишүүнийг УИХ, орон нутгийн иргэдийн хуралд нэр дэвшиж өрсөлдөхөд улс төр, нийгэм, эдийн засаг, бизнесийн хүрээнд бүхий л талаар дэмжих;

30.3. УИХ, орон нутгийн иргэдийн хуралд нэр дэвшүүлэхдээ салбар холбоо, хороо, дэргэдэх байгууллагуудын дарга нарын саналыг оруулна.

30.4. МЗХ-ны салбар холбоо, хороо, зөвлөлийн дарга нарыг сонгуульт албан тушаалын хугацаа дуусгавар болсноор хүндэт тэргүүнээр өргөмжилж, Залуу Удирдагч Сангийн гишүүн болгоно.

30.5. МЗХ-ны идэвхтэн, сонгуульт гишүүний холбооны үйл ажиллагаанд оролцоог үнэлэн шагнал, урамшуулал, сонгуульт албан тушаал, олон улсын болон дотоодын сургалт семинарт оролцуулна.



ТАВДУГААР БҮЛЭГ

САНХҮҮЖИЛТ

Гучиннэгдүгээр зүйл. Өмч хөрөнгө, санхүүжилт

- 31.1. МЗХ-ны өмч хөрөнгө нь МЗХ-ны бүх шатны байгууллага, харьяа байгууллагын оюуны болон материаллаг өмч хөрөнгө, татвар, үйл ажиллагааны орлого, дэмжигч хувь хүн, байгууллага, хамт олны хандиваас бүрдэнэ.
- 31.2. Дэмжигч иргэн хуулийн этгээдээс өгсөн хандив;
- 31.3. Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг;
- 31.4. Холбооны хэвлэл мэдээлэл сурталчилгааны орлого;
- 31.5. Үл хөдлөх хөрөнгийг худалдахаа Y33-ийн зөвшөөрөлтэйгөөр худалдана.
- 31.6. Эд хөрөнгийг худалдах буюу түрээслүүлж ашиглуулснаас олох орлого.
- 31.7. Хуулиар хориглоогүй бусад орлого.
- 31.8. МЗХ-ны санхүүгийн тайлан, шагнал, хандив, дэмжлэг туслалцаа түүнтэй холбоотой мэдээлэл ил тод байна.
- 31.9. МЗХ, салбар холбоо, хороо, зөвлөлийн үйл ажиллагаанд санхүүгийн аудитыг гишүүн дэмжигчийн саналаар оруулж болно.
- 31.10. Төрөөс болон төсвийн санхүүжилт төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд шилэн дансны тухай хуулийг мөрдөнө.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

БУСАД

Гучин хоёрдугаар зүйл. МЗХ-г өөрчлөн байгуулах, татан буулгах

- 32.1. МЗХ-ны ИХ хурлын шийдвэрээр МЗХ-г өөрчлөн байгуулж, эсвэл татан буулгаж болно.
- 32.2. МЗХ-г өөрчлөн байгуулсан эсвэл татан буулгасан тохиолдолд үүсэх харилцааг Монгол Улсын Иргэний хууль, төрийн бус байгууллагын харилцааг зохицуулах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 32.3. МЗХ-ны салбар нэгжийг үүсгэн байгуулахад дээд шатны байгууллагын удирдлага, эсвэл МЗХ-ны Ерөнхийлөгчийн тушаалаар байгуулна.

Гучин гуравдугаар зүйл. Хурлын шийдвэр хүчин төгөлдөр болгох

- 33.1. Энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол МЗХ-ны ИХ, Y33, УЗ болон ХЗ-ийн хурлыг нийт гишүүдийн олонх нь хурэлцэн ирсэн тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзнэ.
- 33.2. МЗХ-ны ИХ, Y33, УЗ-ийн хурлаас тогтоол, ХЗ-ийн хурлаас шийдвэр, Ерөнхийлөгч, ЕНБД тушаал гаргана.
- 33.3. Хурлын шийдвэрийг оролцогчдын цөөнхийн саналаар хүндэтгэж, олонхын саналаар шийдвэрлэнэ.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.СЭРГЭЛЭНБААТАР

